БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улаанхус сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БӨА-2026/102/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Өлгий хот<br>2023 он | Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор: Ж.Айгүл<br>Утас: 70422954 Цахим хаяг: Aigulj@audit.gov.mn<br>Аудитын менежер: Х.Женисбек<br>Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn<br>Ахлах аудитор: М.Айнур<br>Утас: 94159291 Цахим хаяг: ainurm@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан
4.1 Ерөнхий зүйл
4.2 Материаллаг байдал
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

2026.02.25 № 192

танай ______ -ны № ______ -т

УЛААНХУС СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
А.ХОНЫРАТ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу

Улаанхус сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Улаанхус сумын Засаг даргын Тамгын газар нь 2025 онд 1,491.2 сая төгрөгийн батлагдсан төсвөөр ажиллаж, гүйцэтгэлээр 1456.1 сая төгрөг зарцуулж, 97.6 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

**Бусад асуудал**

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

832605000278

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.АЙГҮЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **31,298,066.15** | **84,610,892.15** |
| **33** | **АВЛАГА** | 13,977,566.15 | 16,336,892.15 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 13,977,566.15 | 16,336,892.15 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | - | - |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | - | - |
| 33400 | Зээлийн хүүгийн авлага | - | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 17,320,500.00 | 68,274,000.00 |
| **351** | **Түүхий эд материал** | - | - |
| 35110 | Тусгай зориулалттай материал | - | - |
| 35130 | Эм боох материал | - | - |
| 35200 | Дуусаагүй үйлдвэрлэл | - | - |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | - | - |
| **354** | **Хангамжийн материал** | 7,420,500.00 | 68,274,000.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | - | - |
| 35420 | Аж ахуйн материал | 7,420,500.00 | 68,274,000.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | - | - |
| 35440 | Түлш, шатах тослох материал | - | - |
| 35450 | Барилгын засварын материал | - | - |
| 35460 | Хүнсний материал | - | - |
| 35470 | Бусад хангамжийн материал | - | - |
| 35500 | Биологийн хөрөнгө | - | - |
| 35600 | Мал амьтад | 9,900,000.00 | - |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **9,776,889,897.65** | **9,976,352,507.25** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 9,776,889,897.65 | 9,976,352,507.25 |
| 391 | Газар | - | - |
| **392** | **Биет хөрөнгө** | 9,548,599,154.79 | 9,748,960,074.07 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 3,172,359,673.51 | 3,284,189,557.51 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (475,618,939.82) | (563,774,708.37) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 124,140,834.00 | 425,156,045.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (53,000,342.38) | (75,673,737.52) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 123,509,065.00 | 145,407,511.93 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (55,666,357.15) | (60,679,275.10) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 28,624,371.00 | 39,124,371.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (5,859,552.18) | (9,050,667.51) |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 6,847,437,384.00 | 6,847,437,384.00 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | (525,681,981.06) | (768,470,488.14) |

| | | | |
|---|---|---|---|
| 39211 | Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж | - | - |
| 39212 | Хуримтлагдсан элэгдэл | - | - |
| 39213 | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | - | - |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 416,300,000.00 | 585,610,748.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (47,945,000.13) | (100,316,666.73) |
| 39216 | Дуусаагүй барилга, байгууламж | - | - |
| 39217 | Ном | - | - |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 228,290,742.86 | 227,392,433.18 |
| 39301 | Програм хангамж | 12,529,639.00 | 12,529,639.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,742,896.14) | (2,641,205.82) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 217,504,000.00 | 217,504,000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | - | - |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **9,808,187,963.80** | **10,060,963,399.40** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **39,427,810.60** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | - | 39,427,810.60 |
| **413** | **Өглөг** | - | 39,427,810.60 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | - | - |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | - | - |
| 41330 | Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг | - | - |
| 41340 | Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг | - | - |
| 41350 | Зээлийн хүүгийн өглөг | - | - |
| **4136** | **Бусад өглөг** | - | 39,427,810.60 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | - | 39,038,810.60 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | - | 389,000.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **9,808,187,963.80** | **10,021,535,588.80** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 9,808,187,963.80 | 10,021,535,588.80 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 2,009,407,276.32 | 2,009,407,276.32 |
| 51101 | Өмч: - төрийн | 2,009,407,276.32 | 2,009,407,276.32 |
| 51102 | - хувийн | - | - |
| 51103 | - хувьцаат | - | - |
| 51104 | Халаасны хувьцаа | - | - |
| 51105 | Нэмж төлөгдсөн капитал | - | - |
| 51106 | Эздийн өмчийн бусад хэсэг | - | - |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 6,470,233,143.63 | 6,683,653,035.63 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 6,470,233,143.63 | 6,470,305,410.63 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 213,347,625.00 |
| 51230 | Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс | - | - |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,328,547,543.85 | 1,328,475,276.85 |
| 51400 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - |
| 51500 | Бодлогын өөрчлөлт алдааны залруулга | - | - |
| 51600 | Нөөцийн сан | - | - |

| | | | |
|---|---|---|---|
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **9,808,187,963.80** | **10,060,963,399.40** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,697,695,392.00** | **2,110,530,900.93** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **427,988,050.00** | **19,522,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 427,988,050.00 | 19,522,000.00 |
| 120001 | Хувьцааны ногдол ашиг | - | - |
| 120002 | Хүүгийн орлого | - | - |
| 120003 | Торгуулийн орлого | - | - |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 427,988,050.00 | 19,522,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | - |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | - |
| 1200043 | Урьд оны үлдэгдэлээс санхүүжих | - | - |
| 1200044 | Гадаадын эх үүсвэрээс санхүүжих | - | - |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 427,988,050.00 | 19,522,000.00 |
| 120005 | Түрээсийн орлого | - | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,269,707,342.00** | **2,091,008,900.93** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | - | 614,811,593.93 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | - | - |
| 131002 | Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт | - | - |
| 131003 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | - |
| 131004 | Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх | - | - |
| 131005 | Хөрөнгийн санхүүжилт | - | 614,811,593.93 |
| 131006 | Засгийн газрын тусгай сангаас санхүүжих | - | - |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | - | - |
| 131008 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих | - | - |
| 131009 | Оны эхний үлдэгдлээс санхүүжих | - | - |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 12,022,342.00 | 13,213,507.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | - | - |
| 131102 | Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл | - | - |

| | | | |
|---|---|---|---|
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 12,022,342.00 | 13,213,507.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | - |
| 131106 | Төсвийн урамшуулал | - | - |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 1,257,685,000.00 | 1,462,983,800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 1,257,685,000.00 | 1,462,983,800.00 |
| 132002 | Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт | - | - |
| 132003 | Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/ | - | - |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,599,465,285.11** | **1,897,183,275.93** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,599,465,285.11** | **1,897,183,275.93** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,563,165,003.29 | 1,838,788,037.93 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 844,668,121.85 | 959,185,624.00 |
| 210101 | Үндсэн цалин | 463,101,406.70 | 715,496,513.38 |
| 210102 | Нэмэгдэл | 362,389,715.15 | 225,439,110.62 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | - |
| 210104 | Урамшуулал | 19,177,000.00 | 18,250,000.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | - | - |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 117,452,000.00 | 120,021,800.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 79,867,300.00 | 81,614,700.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 9,396,200.00 | 10,467,400.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,698,100.00 | 3,935,000.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,698,100.00 | 4,800,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 18,792,300.00 | 19,203,900.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 39,290,583.19 | 49,816,400.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,203,377.19 | 6,611,236.00 |
| 210302 | Түлш, халаалт | 34,087,206.00 | 43,205,164.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | - | - |
| 210304 | Байрны түрээс | - | - |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 56,873,300.99 | 64,934,805.60 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,847,100.00 | 3,572,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 47,368,142.00 | 52,970,905.60 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 5,140,058.99 | 8,119,800.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 38,000.00 | - |

| | | | |
|---|---|---|---|
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 480,000.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | - | 271,700.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | - | - |
| 210408 | Бараа материал акталсны зардал | - | - |
| **2105** | **Нормативт зардал** | 648,000.00 | 847,400.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | - | - |
| 210502 | Хоол, хүнс | - | - |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 648,000.00 | 847,400.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,616,800.00 | 2,038,500.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 105,000.00 | - |
| 210602 | Тавилга | - | - |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | - | 14,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,511,800.00 | 2,024,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 8,760,350.00 | 9,236,275.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | - | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,504,000.00 | 5,474,175.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 2,256,350.00 | 3,762,100.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 45,998,920.00 | 157,778,687.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 45,115,920.00 | 154,585,842.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | - | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 77,000.00 | - |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 110,000.00 | 982,800.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 33,000.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 663,000.00 | 1,111,400.00 |
| 210807 | Газрын төлбөр | - | 1,077,645.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | - | - |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | - | 21,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 444,856,927.26 | 474,928,546.33 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 72,805,219.00 | 17,589,762.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 600,300.00 | 1,339,800.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 371,451,408.26 | 455,998,984.33 |
| 210904 | Найдваргүй авлагын алдагдал | - | - |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 36,300,281.82 | 58,395,238.00 |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | - | - |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | - | - |
| 213102 | Засгийн газрын гадаад шилжүүлэг | - | - |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 35,550,000.00 | 51,283,800.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | - | - |

| | | | |
|---|---|---|---|
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | - | - |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | - | 11,220,000.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | - | 12,870,000.00 |
| 213206 | Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт | - | - |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 21,750,000.00 | 17,959,900.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 13,800,000.00 | 9,233,900.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | - |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 750,281.82 | 7,111,438.00 |
| 213501 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | - | - |
| 213502 | Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө | - | - |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 750,281.82 | 7,111,438.00 |
| 213504 | Хөрөнгийн | - | - |
| 213505 | Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт | - | - |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | 98,230,106.89 | 213,347,625.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | - | - |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | 98,230,106.89 | 213,347,625.00 |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,269,707,342.00** | **1,476,197,307.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,269,707,342.00** | **1,476,197,307.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 12,022,342.00 | 13,213,507.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | | |
| 131102 | Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл | | |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | |

| | | | |
|---|---|---|---|
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 12,022,342.00 | 13,213,507.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | |
| 131106 | Төсвийн урамшуулал | | |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 1,257,685,000.00 | 1,462,983,800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 1,257,685,000.00 | 1,462,983,800.00 |
| 132002 | Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт | | |
| 132003 | Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/ | | |
| 132004 | Оны эхний үлдэгдлээс санхүүжих / орон нутгийн төсөв/ | | |
| 132005 | Хөрөнгийн санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага/ | | |
| 132006 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/ | | |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,235,607,342.00** | **1,441,675,607.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,235,607,342.00** | **1,441,675,607.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,199,307,060.18** | **1,383,280,369.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 858,066,937.00 | 960,345,000.00 |
| 210101 | Үндсэн цалин | 476,500,221.00 | 537,285,300.00 |
| 210102 | Нэмэгдэл | 362,389,716.00 | 388,870,900.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | |
| 210104 | Урамшуулал | 19,177,000.00 | 34,188,800.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 117,452,000.00 | 120,227,700.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 79,867,300.00 | 81,820,800.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 9,396,200.00 | 9,601,600.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,698,100.00 | 4,800,800.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,698,100.00 | 4,800,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 18,792,300.00 | 19,203,700.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 39,290,583.19 | 49,816,400.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,211,737.09 | 6,611,236.00 |
| 210302 | Түлш, халаалт | 36,078,846.10 | 43,205,164.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | | |
| 210304 | Байрны түрээс | | |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 56,230,150.99 | 51,798,132.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,242,000.00 | 1,710,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 47,368,092.00 | 41,026,832.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 5,140,058.99 | 7,989,800.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210404 | Ном, хэвлэл | | |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 480,000.00 | 583,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 488,000.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | | |
| 210408 | Бараа материал акталсны зардал | | |
| **2105** | **Нормативт зардал** | 588,000.00 | 259,600.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | | |
| 210502 | Хоол, хүнс | | |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 588,000.00 | 259,600.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 6,056,300.00 | 2,063,200.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 424,000.00 | |
| 210602 | Тавилга | | |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | | 63,200.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,632,300.00 | 2,000,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 10,370,350.00 | 9,572,575.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | | |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,504,000.00 | 5,474,175.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 3,866,350.00 | 4,098,400.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 46,697,370.00 | 159,849,392.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 45,506,370.00 | 158,877,392.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | | |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 184,800.00 | |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 377,700.00 | |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 33,000.00 | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 467,000.00 | 934,200.00 |
| 210807 | Газрын төлбөр | 128,500.00 | |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | | |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | | 37,800.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 64,555,369.00 | 29,348,370.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 63,492,369.00 | 27,504,770.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,063,000.00 | 1,843,600.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **36,300,281.82** | **58,395,238.00** |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | - | - |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | | |
| 213102 | Засгийн газрын гадаад шилжүүлэг | | |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 35,550,000.00 | 51,283,800.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | | |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | | |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | | 24,090,000.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | | |

| | | | |
|---|---|---|---|
| 213206 | Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт | | |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 21,750,000.00 | 17,959,900.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 13,800,000.00 | 9,233,900.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 750,281.82 | 7,111,438.00 |
| 213301 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | | |
| 213302 | Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө | | |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 750,281.82 | 7,111,438.00 |
| 213304 | Хөрөнгийн | | |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **34,100,000.00** | **34,521,700.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **34,100,000.00** | **34,521,700.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **34,100,000.00** | **34,521,700.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 34,100,000.00 | 34,521,700.00 |
| 220001 | Барилга байгууламж | | |
| 221001 | Их засвар | | |
| 222001 | Тоног төхөөрөмж | | |
| 223001 | Бусад хөрөнгө | | |
| 224001 | Стратегийн нөөц хөрөнгө | | |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 34,100,000.00 | 34,521,700.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(34,100,000.00)** | **(34,521,700.00)** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | - | - |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | - |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| С01 | **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 2,009,407,276.32 | 1,328,547,543.85 | 6,470,233,143.63 | 9,808,187,963.80 |
| С02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | 0.00 |
| С03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **2,009,407,276.32** | **1,328,547,543.85** | **6,470,233,143.63** | 9,808,187,963.80 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | | | 0.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | | | | 0.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | 0.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | | 0.00 |
| C08 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **2,009,407,276.32** | **1,328,547,543.85** | **6,470,233,143.63** | 9,808,187,963.80 |
| D01 | **2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **2,009,407,276.32** | **1,328,547,543.85** | **6,470,233,143.63** | 9,808,187,963.80 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | 72,267.00 | 72,267.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **2,009,407,276.32** | **1,328,547,543.85** | **6,470,305,410.63** | 9,808,260,230.80 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | -72,267.00 | | -72,267.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | | 0.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | 0.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | 0.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | 193,872,625.00 | 193,872,625.00 |
| D09 | **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **2,009,407,276.32** | **1,328,475,276.85** | **6,664,178,035.63** | **10,002,060,588.8** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

| **Эдийн засгийн ангилал** | **Үзүүлэлт** | **Тайлант оны** | |
|---|---|---|---|
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,491,169,800.00 | 1,456,132,362.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,491,169,800.00 | 1,456,132,362.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,439,885,800.00 | 1,404,848,562.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 961,783,300.00 | 960,345,000.00 |
| 210101 | Үндсэн цалин | 541,156,800.00 | 537,285,300.00 |
| 210102 | Нэмэгдэл | 395,076,500.00 | 388,870,900.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | |
| 210104 | Урамшуулал | 25,550,000.00 | 34,188,800.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 120,222,900.00 | 120,021,600.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 81,816,000.00 | 81,614,700.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 9,601,600.00 | 9,601,600.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,800,800.00 | 4,800,800.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,800,800.00 | 4,800,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 19,203,700.00 | 19,203,700.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 49,816,300.00 | 49,816,400.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,900,000.00 | 6,611,236.00 |
| 210302 | Түлш, халаалт | 41,916,300.00 | 43,205,164.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | | |
| 210304 | Байрны түрээс | | |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 49,697,000.00 | 41,872,500.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,751,500.00 | 1,710,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 36,834,500.00 | 31,793,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 8,826,000.00 | 7,298,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | - | |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 700,000.00 | 583,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 585,000.00 | 488,000.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | - | |
| **2105** | **Нормативт зардал** | 778,500.00 | 259,600.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | | |
| 210502 | Хоол, хүнс | | |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 778,500.00 | 259,600.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 22,511,700.00 | 12,584,900.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 20,321,700.00 | 10,521,700.00 |
| 210602 | Тавилга | - | |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 190,000.00 | 63,200.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,000,000.00 | 2,000,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 10,012,400.00 | 7,780,400.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | | |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,864,500.00 | 3,682,000.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 6,147,900.00 | 4,098,400.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 189,532,700.00 | 183,741,392.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 186,909,000.00 | 182,769,392.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 503,000.00 | |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 184,800.00 | |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 392,000.00 | |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 120,400.00 | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,245,000.00 | 934,200.00 |
| 210807 | Газрын төлбөр | 128,500.00 | |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | - | |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 50,000.00 | 37,800.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 35,531,000.00 | 28,426,770.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 30,000,000.00 | 26,583,170.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,531,000.00 | 1,843,600.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 51,284,000.00 | 51,283,800.00 |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | - | - |

| | | | |
|---|---|---|---|
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | | |
| 213102 | Засгийн газрын гадаад шилжүүлэг | | |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 51,284,000.00 | 51,283,800.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | | |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | | |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 24,090,000.00 | 24,090,000.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | - | |
| 213206 | Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт | - | |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 17,960,000.00 | 17,959,900.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 9,234,000.00 | 9,233,900.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | |
| **13** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,491,169,800.00 | 1,456,132,362.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | - | - |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | | |
| 131006 | Засгийн газрын тусгай сангаас санхүүжих | | |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | | |
| 131008 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих | | |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,491,169,800.00 | 1,456,132,362.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 1,491,169,800.00 | 1,456,132,362.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | | |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | | |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | - | - |
| 610001 | Төсвийн байгууллага | | |
| 610002 | Төсвөөс гадуур байгууллага | | |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 27.00 | 37.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 14.00 | 14.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 9.00 | 9.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 4.00 | 4.00 |
| 620004 | Гэрээт ажилтан | - | 10.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **28.00** | **38.00** |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 10.00 | 10.00 |
| 650002 | Төрийн тусгай албан хаагч (ТТ) | | |
| 650003 | Ажлын албаны албан хаагч (АА) | | |
| 650004 | СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | | |
| 650005 | ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШУ) | | |
| 650006 | Соёл урлагийн салбарын төрийн їйлчилгээний албан хаагч (ТҮСУ) | | |

| | | | |
|---|---|---|---|
| 650007 | Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ) | | |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | 4.00 | 4.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 1.00 | 11.00 |
| 650010 | Гэрээт ажилтан | | |
| 650011 | Улс төрийн албан хаагч (УТ) | 13.00 | 13.00 |

### 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **-** | **12,953,507.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **-** | **12,953,507.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | - | 12,953,507.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | - | 206,100.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | | 206,100.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | | |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | | |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | | |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | | |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | - | 10,493,232.00 |
| 210401 | Бичиг хэрэг | | |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 9,893,232.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | | 600,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | | |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | - | 1,792,175.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | | |
| 210702 | Дотоод албан томилолт | | 1,792,175.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | - | 108,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 108,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | | |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | - | 354,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 354,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **-** | **260,000.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 213303 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | | |
| 213403 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг | | |
| 213503 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | | 260,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | - | 12,953,507.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 12,953,507.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 12,953,507.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | |
| 131106 | Төсвийн урамшуулал | | |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

### 3.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хуулийн хэрэгжилтийн хангаж ажилласан байна.  Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил дараах зөрчлүүд илэрсэн.

Илрүүлэлт:

Улаанхус сумын ЗДТГ нь 2025 онд төсвийн хөрөнгөөр 21.1 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг гэрээ шууд хийх замаар худалдан авсан ба худалдан авах ажиллагааны цахим сайтад 15.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг худалдан авах урилга тавьж, 6.1 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг худалдан авах урилга тавиагүй байна.

Энэ нь  Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Төсвийн хөрөнгөөр 20.0 сая төгрөгийн дотор худалдан авах тавилга эд хогшил, тоног төхөөрөмжийг худалдан авах саналыг цахим сайтад нийтлэж,  худалдаж авахыг зөвлөмж болгов.

### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс санхүүгийн тайлангийн аудитын программд орсон мэдээллийн хэрэгжилтийг шалгаж үзэхэд нийт мэдээлбэл зохих 26 мэдээллээс 2 мэдээллийг оруулаагүй байна. Шилэн дансны мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 86.2 хувьтай байна.Тухайлбал:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3-д “тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан” гэсэн заалтын дагуу тендер шалгаруулалттай холбоотой 15.0 сая төгрөгийн тендертэй холбоотой баримт бичиг, гүйцэтгэлийг, 6.4.8-д “Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” хэсэгт зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбар хэсэгт 33.0 сая төгрөгийн 11 тушаал шийдвэрийг оруулаагүй байсан.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3-д “тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих

шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан", 6.4.8-д "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэсэнд нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн хөрөнгөөр 20.0 сая төгрөг дотор худалдан авах худалдан авах тавилга эд хогшил, тоног төхөөрөмжийг цахим сайтаас худалдан авах, хөрөнгө зарцуулах 33.0 сая төгрөгийн 11 тушаал шийдвэрийг шилэн дансны цахим сайтад нөхөн байршуулахыг зөвлөмж болгов.

**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт 716.9 сая төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад 716.9 сая төгрөгийн алдааг залрууллаа. *Залруулсан алдаа:*

- Төсвийн гүйцэтгэлийн тайланд нийт урсгал зардлын төлөвлөгөөг 118.7 сая төгрөгөөр, төсвийн гүйцэтгэлийг 24.0 сая төгрөгөөр дутуу илэрхийлснийг залруулсан.
- Санхүүгийн үр дүнгийн тайланд бараа материалын үнэ төлбөргүй авсан орлогыг 554.8, сая төгрөгөөр илүү, үндсэн хөрөнгийн хөрөнгийн санхүүжилтийн орлогыг 554.8 сая төгрөгөөр дутуу илэрхийлснийг залруулсан.
- Хатуу оргил трейдинг ХХК-наас авсан 19.4 сая төгрөгийн өвсийг бараа материалд орлого авч, үлдэгдэлд тайлагнаагүй байсныг залруулсан.

Энэ нь Сангийн сайдын 2023 оны 229 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам", УСНББОУС 1 стандарт, толилуулга гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 36.0 сая төгрөгийн зөрчил[2] илэрсэн.

**5.1 Төлбөрийн акт**

Аудитаар 1.7 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

1. Сумын Засаг даргын 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн Б/17 дугаар захирамжаар Тамгын газрын даргад аюулгүй байдлын шалгалтад хамрагдаж, тэнцсэн талаар ямар нэгэн шийдвэр гараагүй байхад нууц хариуцсан ажилтны нэмэгдлийг үндсэн цалингийн 15 хувиар тогтоож, 2025 оны 7 дугаар сараас 12 сар хүртэл хугацаанд нийт 1.7 сая төгрөгийн нэмэгдлийг хууль бус олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолоор баталсан "Төрийн болон албаны нууц хамгаалах ажилтанд цалингийн нэмэгдэл олгох журам"-ын 1.2-т "Нууц хамгаалах

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

ажилтнаар тагнуулын байгууллагын аюулгүй байдлын шалгалтад хамрагдаж, тэнцсэн хүнийг тухайн байгууллагын удирдлагын шийдвэрээр томилно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Журам зөрчиж олгосон 1.7 сая төгрөгийн нууцын нэмэгдлийг ЗДТГ-ын даргаар нөхөн төлүүлэх акт тогтоов.

**5.2 Албан шаардлага**

Аудитын дүнгээр албан шаардлага өгөгдөөгүй.

**5.3 Зөвлөмж**

Аудитаар 4.6 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Нягтлан бодох бүртгэл хөтлөлт, тайлагналтай холбоотой асуудал***

1.1.Илрүүлэлт:

1.Нярав нь бараа материалын тайлан, агуулахын журналыг хангалтгүй хөтөлсөн. Тухайлбал: бараа материалын тайланг бараа материалын төрлөөр сар бүр хөтлөөгүй, бараа материалын агуулахын журналыг хөтлөхдөө эхний, эцсийн үлдэгдлийг гаргаж, дүгнээгүй, бараа материалын тайланд орлого, зарлагын падаан, шаардах хуудсыг бараа материалын төрлөөр тус тусад нь хавсаргаагүй, нийт орлого, зарлагын падааныг хольж үдсэн, замбараагүй байдалтай байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 14 дүгээр зүйлийн 14.3.1-д “анхан шатны баримт бүрдүүлэх” 14.3.2-д “журналд бичих” 14.4.1-д “аж ахуйн бүх ажил, гүйлгээ”, 14.4.5-д “бүх орлого”, 14.4.6-д “бүх зардал” гэсэнд нийцэхгүй байна.

1.1. Өгсөн зөвлөмж:

Нярвын бараа материалын тайлан, журналыг зохих журмын дагуу хөтөлж, баримт материалыг эмх замбараатай үдэж цэгцлэх,

*2.1.Илрүүлэлт:*

1.Тайлант онд халаалтын зардалд гэрээнд тусгагдсан дүнгээс 4.6 сая төгрөгийг илүү шилжүүлсэн бөгөөд энэ нь урьд оны 12 дугаар сарын халаалтын өглөгийг санхүүгийн тайланд өглөгөөр тусгаж харуулаагүй орхигдуулсантай холбоотой байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэнд нийцэхгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Халаалт нийлүүлэгч компанитай жилийн эцсийн тооцоог хийж, тооцоогоор үүссэн өглөгийг санхүүгийн тайланд үнэн зөв тусгаж тайлагнаж ажиллах;

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайлангийн үзүүлэлтийг үнэн зөв тайлагнаагүй | 3 | 717,334.1 | | | 3 | 717,334.1 | 2 | 717,334.1 | | | | |
| **Дүн** | 3 | 717,334.1 | | | 3 | 717,334.1 | 2 | 717,334.1 | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Журам зөрчиж, нэмэгдэл цалин олгосон | 1 | 1,675.8 | 1 | 1,675.8 | | | | | | | | |
| Бараа материалын тайлан, агуулахын журналыг хангалтгүй хөтөлсөн | 1 | | | | | | 1 | 0 | | | | |
| Өмнөх оны халаалтын өрийг бүртгэл тайланд тусгаагүй байсан | 1 | 4,629.5 | | | | | 1 | 4,629.5 | | | | |
| **Дүн** | **3** | **6305.3** | **1** | 1,675.8 | | | **2** | 4,629.5 | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансны хэрэгжилттэй холбоотой 2 мэдээллийг оруулаагүй орхигдуулсан | 2 | 48,084.9 | | | | | 2 | 48,084.9 |
| **Дүн** | **2** | **48,084.9** | | | | | **2** | **48,084.9** |
| Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Тайлант онд 21150.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг шууд гэрээ хийх замаар худалдан авсны 6150.0 мянган төгрөгийн урилгыг цахим сайтад тавиагүй. | **1** | **6,150.0** | | | | | **1** | **6,150.0** |
| **Дүн** | **1** | **6,150.0** | | | | | **1** | **6,150.0** |
| **Нийт дүн** | **3** | **54,234.9** | | | | | **3** | **54,234.9** |